

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2023 ОНЫ 08 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 08 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
<b>Үүрэг даалгавар НЭГ:</b> Нийслэлийн Татварын газраас дүүргүүдийн Татварын хэлтсүүдийг удирдлага арга зүйгээр ханган, орлого бүрдүүлэх нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, орлого бүрдүүлэх ажлаа эрчимжүүлж ажиллах.				
1	<p><b>Сарын дүнгээр:</b> 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Улсын төсөвт 4,750,305.00 мянган төгрөгийн төлөвлөгөөг 5,483,851.24 мянган төгрөг буюу 115.4%,</li> <li>➢ Нийслэлийн төсөвт 306,766.00 мянган төгрөгийн төлөвлөгөөг 439,831.95 мянган төгрөг буюу 143.4%,</li> <li>➢ Дүүргийн төсөвт 13,750,255.00 мянган төгрөгийн төлөвлөгөөг 13,828,378.05 мянган төгрөг буюу 100.5%,</li> <li>➢ Нийт дүнгээр 18,807,326.00 мянган төгрөгийн төлөвлөгөөг 19,752,061.25 мянган төгрөг буюу 105.0%-ийн гүйцэтгэлтэй биелүүлэн ажилласан.</li> </ul> <p><b>Өссөн дүнгээр:</b> 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Улсын төсөвт 33,756,123.00 мянган төгрөгийн төлөвлөгөөг 37,151,875.40 мянган төгрөг буюу 110.0%,</li> <li>➢ Нийслэлийн төсөвт 6,123,146.00 мянган төгрөгийн төлөвлөгөөг 5,771,544.24 мянган төгрөг буюу 94.3%,</li> <li>➢ Дүүргийн төсөвт 100,400,389.00 мянган төгрөгийн төлөвлөгөөг 101,361,134.16 мянган төгрөг буюу 100.9%, Нийт дүнгээр 140,279,658.00 мянган төгрөгийн төлөвлөгөөг 144,284,553.80 мянган төгрөг буюу 102.3%-ийн гүйцэтгэлтэй биелүүлэн ажиллаж байна.</li> </ul>	2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 102%-д хүргэн ажилласан.	2023 оны 8 дугаар сарын төлөвлөгөөг сар, өссөн дүнгээр биелүүлэн ажиллана.	100
<b>Үүрэг даалгавар ХОЁР:</b> 2023-2024 өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг бүх шатандаа эрчимжүүлж ажиллах.				
2	Чингэлтэй дүүргийн Засаг даргын А/253 дугаар захирамжаар 55 хүний бүрэлдэхүүнтэй өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулагдаж, дүүргийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 12 салбар 125 заалттай төлөвлөгөө боловсруулж			70

<p>хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн дүүргийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулсан ажиллаж байна.</p> <p>2023 оны 07 дугаар сарын байдлаар өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц 70,3 хувьтай байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Нийтлэг үйлчилгээний газар -85 хувь</li> <li>2. Боловсролын хэлтэс - 65 хувь</li> <li>3. Онцгой байдлын хэлтэс – 54,5 хувь</li> <li>4. Эрүүл мэндийн төв – 75,1 хувь</li> <li>5. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв - 85 хувь</li> <li>6. ОСНААУГ-ын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 6 -41 хувь</li> <li>7. ОСНААУГ-ын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 7 -39 хувь</li> <li>8. “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК -91,6 хувь</li> <li>9. “Найши трейд” ХХК -80 хувь</li> <li>10. “Соёндрийм” ХХК -70,5 хувь</li> </ol> <p><b>Хувийн халаалтын уурын зуухнууд:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>11. Ану сервис” ХХК -83 хувь</li> <li>12. “Элбэг дулаан” ХХК-75 хувь</li> </ol> <p><b>Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв</b> Өвөлжилтийн бэлтгэл хангах ажил 85 хувьтай.</p> <p>2023 онд хийгдэж засварын ажлаар 600 тоолуурын нэгдсэн хайрцагт ашиглалт сайжруулах засварын ажил хийгдэхээс 510 тоолуурын нэгдсэн хайрцагт засвар хийгдсэн. Техник зохион байгуулалтын арга хэмжээгээр 1,6 метрээс өндөрт байрлалтай 15 тоолуурын нэгдсэн хайрцаг буулгах ажил хийгдсэн.</p> <p>Давхардсан тоогоор нийт 5270 тоолуурын нэгдсэн хайрцагт үзлэг хийгдсэн.</p> <p><b>Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрынХэрэглэгчдэд үйлчлэх төв 6</b> Өвөлжилтийн бэлтгэл хангах ажил 41 хувьтай. Чингэлтэй дүүргийн 4, 5, 6, 9, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 110 байр, 645 аж ахуй нэгж байгууллагын халаалт, халуун хүйтэн усыг түгээж, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ эрхэлдэг.</p> <p><b>Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 7</b> Өвөлжилтийн бэлтгэл хангах ажил 39 хувьтай.Чингэлтэй дүүргийн 1, 2, 3 дугаар хорооны 96 байрны 3405 өрх, 867 аж ахуй нэгж байгууллагын халаалт, халуун хүйтэн усыг түгээж, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ эрхэлдэг.</p> <p><b>“Ану сервис” ХХК, “Элбэг дулаан” ХХК зэрэг хувийн халаалтын уурын зуухнууд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байна.</b></p> <p><b>Ану сервис” ХХК</b> Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц 83 хувьтай. 57, 17, 49, 72-р сургууль, 56, 102, 86-р цэцэрлэгийн халаалтыг хариуцаж ажилладаг. Чех улсад үйлдвэрлэгдсэн хатуу шингэн түлшээр ажилладаг “Dakon” маркийн 2 ш зуухтай ажиллаж байна.</p>		
---	--	--

	<p><b>“Элбэг дулаан” ХХК</b>  Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц 75 хувьтай.18 дугаар хорооны цогцолбор, 37-р сургууль, 103, 247-р цэцэрлэг, Дэлхийн зөн олон улсын байгууллагын халаалтыг хариуцаж ажилладаг. БНСУ-д үйлдвэрлэгдсэн хатуу шингэн түлшээр ажилладаг N1.8, DZL 1.8 маркийн 2 ш зуухтайгаар тус тус ажиллаж байна.</p>			
<p><b>Үүрэг даалгавар ГУРАВ:</b> <i>Үерийн далан суваг, ус зайлуулах шугам сүлжээний цэвэрлэгээ үйлчилгээ болон засвар шинэчлэлтийн ажлыг батлагдсан графикийн дагуу хийж гүйцэтгэн, үер усны аюулаас тогтмол урьдчилан сэргийлж ажиллах.</i></p>				
3	<p>Дүүргийн 7 дугаар хороо Зурагтын шинэ эцэс, автобусны буудлын урд хэсэгт байрлах авто замын доорх бороо, үерийн ус зайлуулах гаргалгаа нь лаг, шавраар дүүрч бөглөрснийг байгаа тул яаралтай хариуцагч байгууллагыг тодорхой болгож, арга хэмжээ авхуулахаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд, Геодези, усны барилга, байгууламжийн газар ОНӨААТҮГ-т 3/1896 тоот албан бичгээр,</p> <p>➢ 8 дугаар хороо, Тасганы овооны баруун талын бороо, үерийн ус зайлуулах далан сувгийн эхлэл хэсэг нь үерийн усыг хангалттай хэмжээнд хүлээн авч, нэвтрүүлж чадахгүй байгаагаас тухайн орчны айл өрх, аж ахуйн нэгж байгууллагууд үерт автсан тул тус байршилд үерийн ус зайлуулах байгууламжийг стандартын дагуу яаралтай хийж гүйцэтгүүлэхийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Геодези, усны барилга, байгууламжийн газар ОНӨААТҮГ-т 3/1884 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p> <p>Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, постер, шторк бэлтгэн дүүргийн 1-24 дүгээр хорооны дотор байрлах дэлгэцүүдээр давтагдсан тоогоор 130 удаа, хэлтсийн фэйж хуудас болон chd.nema.gov.mn сайтад нийт 50 мэдээ, байршуулан нийт 12304 иргэнд хүргэн ажиллаж байна.</p> <p>Чингэлтэй дүүргийн Нийслэлийн засаг захиргааны III байрны лед дэлгэц, MN Tower төвийн гадна талбайн лед дэлгэц, дүүргийн 7-24 дүгээр хорооны цахим дэлгэц, Алтжин бөмбөгөр худалдааны төвийн цахим дэлгэцээр тус бүр өдөрт 5-6 удаагийн давтамжтайгаар нийт 16 удаа хүргэж сурталчилж ажилласан.</p> <p>Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын баталсан усны ослоос урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлээр Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Ангиллын сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч гал сөнөөгч, ахлах ахлагч М.Мөнхжаргал, Ангиллын сургалт сурталчилгаа, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан мэргэжилтэн, дэслэгч С.Урантөгс 2023 оны 08 дугаар сарын 05, 12-ны өдрүүдэд Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 10 дугаар анги, Баянгол дүүргийн Гал түймэр унтраах, аврах 18 дугаар ангийн алба хаагчидтай хуваарийн дагуу Яармагийн гүүрнээс Маршалын гүүр хүртэлх 6.2 км газарт эргүүлийн үүрэг гүйцэтгэж Сэлбэ гол болон Туул голын усанд иргэдийг осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор дрон /Нисгэгчгүй нисэх төхөөрөмж/-ыг ашиглан агаараас иргэдийн хөдөлгөөнд тандалт хийж зураг болон бичлэг хийн дүрсжүүлэх, иргэдэд сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг хүргэн, тараах материал өгч ажиллана.</p>		<p>“Эрсдэлгүй аялал-Эндэлгүй зун” нөлөөллийн аяныг зохион байгуулсан нь иргэдэд үр дүнгээ өгч тохиолдож болох эрсдэлийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болж гол, усны ойролцоо гэр бүлээрээ амарч зугаалж байгаа эцэг, эх томчууд хүүхдүүддээ тавих хараа хяналт нь ихээр сайжирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж чадаж байна. Энэхүү аяныг жил бүрийн 6 дугаар сараас 9 дүгээр сарын хооронд уламжлал болгон тогтмол зохион байгуулах саналтай байна.</p>	70

	Чингэлтэй дүүргийн 19-24 дүгээр хорооны зуслангийн бүсэд баннер байршуулан ажилласан.			
<b>Үүрэг даалгавар ДӨРӨВ:</b> Авто зам, замын байгууламжийг хэсэгчлэн буюу бүтэн хааж хийгдэж байгаа зам засварын ажлуудыг хөдөлгөөний ачаалал эхлэхээс өмнө буюу 8 сарын 15-ны өдрийн дотор гүйцэтгэж дуусгахаар ажлаа зохион байгуулах.				
4	Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт Улаанбаатар зам засвар, арчлалтын газраас: <ul style="list-style-type: none"> <li>➢ Найман шарга худалдааны төвийн авто зам</li> <li>➢ Алтжин бөмбөгөр худалдааны төвийн авто замын засвар шинэчлэлтийн ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж байна.</li> </ul> Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар: <ul style="list-style-type: none"> <li>➢ “Дэнжийн 1000-ын Цагаан байрны уулзвараас Хүчит шонхор захын уулзвар хүртэлх туслах замын өргөтгөл” төсөл арга хэмжээг “Экспресс зам” ХХК хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд “Хүчит шонхор” захын уулзвараас 163 дугаар худаг хүртэлх авто замыг хэсэгчлэн хааж авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг хийж байна.</li> </ul>			90
<b>Үүрэг даалгавар ТАВ:</b> Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөл боловсруулагдаж байгаатай холбогдуулан төлөвлөгөөний төсөлд тусгах санал ирүүлсэн байгууллагууд дахин нягталж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдтэй уулзаж саналаа нэгтгэн боловсруулж, эцэслэн танилцуулах.				
5	“Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний төсөлд хэрэгжүүлэх боломжтой 7 төсөл арга хэмжээний саналыг 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 3/1450 тоот албан бичгээр НЗДТГ-т хүргүүлэн ажилласан.			100

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Л.БАЯРМАА

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.ХУЛАН

НЭГТГЭСЭН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН Т.ТҮВШИНЖАРГАЛ